



**МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2014 оны 7 сарын 21 өдөр

Дугаар A-116

Улаанбаатар хот

Г Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах  
журам, түүний бүрэлдэхүүнийг батлах тухай

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Хамтын ажиллагааны зөвлөлийн ажиллах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2.Хамтын ажиллагааны зөвлөлийн зөвлөмж, саналын хэлбэр, загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулж Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 160 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцугай.

4.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн мэдээллийн алба (Б.Төмөрбат), Тамгын газар (Д.Чимэд-Юндэн), Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр)-т тус даалгасугай.



14.10.29

Монголбанкны Ерөнхийлөгчийн  
2014 оны 7 дугаар сарын 21-ны өдрийн  
№ - 116.. тушаалын нэгдүгээр хавсралт

## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 22 дугаар зүйлд заасны дагуу Хамтын ажиллагааны зөвлөл (цаашид “ХАЗ” гэх)-ийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрднө.

1.2.ХАЗ нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.

1.3.ХАЗ нь “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцох, Санхүүгийн мэдээллийн албаны стратеги, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны зардлыг батлахад Монголбанкны Ерөнхийлөгчид санал өгөх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх Монгол Улсын эрсдэлийг үнэлэх, түүнийг бууруулах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар бодлого, зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл болно.

### Хоёр. Хамтын ажиллагааны зөвлөлийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт

2.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22.2-т заасны дагуу ХАЗ-д Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Хууль зүйн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба, Авлигатай тэмцэх газар (цаашид “оролцогч байгууллага” гэх)-ын төлөөлөл оролцно.

2.2.Оролцогч байгууллагын удирдлагын бичгээр санал болгосноор тэдгээрийг ХАЗ-д төлөөлөх эрх бүхий албан тушаалтыг Монголбанкны Ерөнхийлөгч томилно.

2.3.Эрх бүхий албан тушаалтан нь оролцогч байгууллагын газар (хэлтэс)-ын дарга буюу түүнтэй адилтгах хэмжээний албан тушаалтан байна.

2.4.ХАЗ-ийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль зүйн яам, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Гадаад харилцааны яам, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар 1 жилийн хугацаатай ээлжлэн удирдана.

2.5.ХАЗ-ийн нарийн бичгийн даргыг Санхүүгийн мэдээллийн албаны дарга гүйцэтгэнэ.

## Гурав. Хамтын ажиллагааны зөвлөлийн чиг үүрэг

### 3. ХА3 нь дараах чиг үүрэгтэй:

3.1.“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хангуулах зорилгоор зөвлөмж, санал гаргах;

3.2. Монгол Улсын хэмжээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг судлах, эрсдэлийн үнэлгээг гаргах үйл ажиллагааг жил бүр зохион байгуулах. Үүнд төрийн байгууллага, хувийн хэвшил, олон улсын байгууллагатай хамтарч болно;

3.3. Энэ журмын 3.2-т заасан эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг багасгах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай тэмцэх ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах талаар зөвлөмж гаргах;

3.4. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх нөхцөл байдал, үр дунгийн талаар мэдээлэл солилцох;

3.5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, санал гаргах;

3.6. Гаргасан зөвлөмж, саналын дагуу оролцогч байгууллагаас хэрэгжүүлж буй арга хэмжээтэй танилцах;

3.7. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль,” холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэхтэй танилцаж мөрдүүлэх талаар санал, зөвлөмж гаргах;

3.8. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль,” холбогдох бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр гаргасан дүрэм, журам, үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө түүний хэрэгжилтийн байдалтай танилцаж, зохих арга хэмжээ авахыг оролцогч байгууллагын удирдлагад санал болгох;

3.9. Оролцогч байгууллага хоорондын харилцааны талаар зөвлөмж өгч, тэдгээрийн хамтын ажиллагааг сайжруулах тал дээр арга хэмжээ авах;

3.10. Эрх бүхий албан тушаалтнаар дамжуулан тэдгээрийн харьялагдах байгууллагад “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, түүний хэрэгжилтийн талаар зөвлөмж гаргах;

3.11. “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”, холбогдох бусад хууль тогтоомжийг олон улсын стандарт, ялангуяа Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-ын 40 зөвлөмжид нийцүүлэх талаар зөвлөмж гаргах;

3.12.Оролцогч байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон бус нутаг, олон улсын байгууллагын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажилтай уялдуулахад дэмжлэг үзүүлэх;

3.13.Оролцогч байгууллагынхаа ажил хариуцсан албан хаагчдад зориулж мэргэшсэн сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.14.ХАЗ-ийн гишүүд оролцогч байгууллагад хамаарах нууцыг чандлан хадгалах;

3.15.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ХАЗ-ийн гишүүн байгууллагын талаарх өргөдөл, гомдлыг хэлэлцэж, түүний дагуу авах арга хэмжээний талаар зөвлөмж гаргах;

3.16.ХАЗ-өөс гаргасан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.17.ХАЗ-өөс гаргасан санал, зөвлөмжид оролцогч байгууллагын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулах;

3.18.ХАЗ-өөс гарах зөвлөмж, саналын загварыг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

#### **Дөрөв. ХАЗ-ийн хурал**

4.1.ХАЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь ХАЗ-ийн хурал /цаашид “зөвлөлийн хурал” гэх/ байна.

4.2.Зөвлөлийн хурлыг ХАЗ-ийн дарга удирдах бөгөөд түүний эзгүйд ХАЗ-ийн нарийн бичгийн дарга хурлыг удирдан явуулна.

4.3.Шаардлагатай гэж үзвэл ХАЗ-ийн даргын шийдвэрээр ХАЗ-өөс гарах санал, зөвлөмжийг хуралдахгүйгээр ажлын шугамаар гаргаж болно. Ингэхдээ ХАЗ-ийн нарийн бичгийн дарга ХАЗ-ийн зөвлөмжийн төслийг эрх бүхий албан тушаалтуудаар дамжуулан оролцогч байгууллагад цахим хэлбэрээр дамжуулж, саналыг хурааж авна.

4.4.ХАЗ нь жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Ээлжит бус хурлыг зөвлөлийн даргын санаачилга, эсхүл оролцогч байгууллагын төлөөллийн дийлэнх олонхийн саналаар зарлан хуралдуулж болно.

4.5.ХАЗ-ийн хурал нь оролцогч байгууллагын төлөөллийн олонх оролцсоноор хүчин төгөлдөр болно.

4.6.ХАЗ-ийн хурлын тов (байршил, цаг), түүгээр хэлэлцэх асуудлыг ХАЗ-ийн нарийн бичгийн дарга оролцогч байгууллагад хурал эхлэхээс ажлын гурав хоногийн өмнө албан бичгээр юмуу цахим шуудангаар тараасан байна.

4.7.ХАЗ нь зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцож буй гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд ХАЗ-ийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

4.8.ХАЗ нь хурлаар эсхүл ажлын шугамаар хэлэлцсэн асуудлын талаар оролцогч байгууллагын удирдлагад мэдээлэл өгөх, түүнчлэн тодорхой асуудлын биелэлтийг хангахыг зөвлөсөн шийдвэрийг тухай бүр гаргаж болно. ХАЗ-ийн шийдвэрийн хэлбэр нь зөвлөмж байх бөгөөд зөвлөмжийг ХАЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

4.9.ХАЗ-ийн шийдвэрийн хэрэгжилт, тайлбарыг оролцогч байгууллага ХАЗ-ийн хуралд танилцуулна.

4.10.Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг Санхүүгийн мэдээллийн албаны ажилтан хөтөлнө.

4.11.Зөвлөлийн хурлын тэмдэглэлд хурал даргалагч, тэмдэглэл хөтлөгч гарын үсэг зурна.

4.12.Зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтлөгч нь хэлэлцсэн асуудлаар гишүүдээс хэлсэн уг, тавьсан саналыг хурлын тэмдэглэлд үнэн зөв, бүрэн гүйцэд бичиж тэмдэглэх ба тэмдэглэлд тусгасан шийдвэрт дараа нь утга агуулгын өөрчлөлт оруулахыг хориглоно.

4.13.ХАЗ-ийн хурлын тэмдэглэл, хурлаар хэлэлцсэн асуудалтай холбогдох материалыг Санхүүгийн мэдээллийн алба хадгалах бөгөөд, ХАЗ-ийн гишүүд материалытай Санхүүгийн мэдээллийн албан дээр ирж танилцаж болно.

4.14.Зөвлөлийн хурлын тэмдэглэлд тухайн хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт, холбогдох материалыг хавсаргана.

#### **Тав.ХАЗ болон түүнд оролцох эрх бүхий албан тушаалтын бүрэн эрх**

5.1.ХАЗ нь дараах бүрэн эрхтэй:

5.1.1.Оролцогч байгууллагын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд хамаарах үйл ажиллагааны тайланг оролцогч байгууллагаас гаргуулах;

5.1.2.Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар оролцогч байгууллагад өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх илтгэлийг ХАЗ-ийн хурлаар хэлэлцэх;

5.1.3.Оролцогч байгууллагын удирдлагатай ХАЗ-ийн хурлаар тухайлан хэлэлцсэн асуудлаар ярилцаж санал солилцох;

5.1.4.ХАЗ-ийн хурлаар хэлэлцсэн аливаа асуудлын биелэлтийг хангаж ажиллахыг оролцогч байгууллагын удирдлагад зөвлөх;

5.1.5.Оролцогч байгууллагын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд хамаарах үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал гаргах;

5.1.6.Хуульд заасан бусад бүрэн эрхийг эдэлнэ.

5.2.ХАЗ-ийн дарга нь ХАЗ-ийн эрх бүхий албан тушаалтын бүрэн эрхийг эдлэхээс гадна ХАЗ-ийг тэргүүлж, хуралдааныг товлох, даргалах эрхтэй ба түүний эзгүйд нарийн бичгийн дарга нь хурал даргална.

5.3.ХАЗ-д оролцогч байгууллагын эрх бүхий албан тушаалтан дараах эрхтэй:

5.3.1.ХАЗ-ийн хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх;

5.3.2.ХАЗ-ийн чиг үүрэгт хамаарах тодорхой асуудлыг хариуцан ажиллаж, гүйцэтгэл, үр дүнгийн талаар хуралд мэдээлэх;

5.3.3.ХАЗ-ийн шийдвэрийн дагуу оролцогч байгууллагын үйл ажиллагаатай танилцах;

5.3.4.ХАЗ-ийн даргын зөвшөөрснөөр ХАЗ-ийн шийдвэрт хяналт тавьж үр дүнг ХАЗ-ийн хуралд мэдээлэх;

5.3.5.ХАЗ-ийн чиг үүрэгт холбогдох асуудлаар оролцогч байгууллагаас баримт материал гаргуулан авч болно.

#### **Зургаа.ХАЗ-ийн төлөөлөгчдийн ажлын хөлс, зардал**

6.1.Эрх бүхий албан тушаалтанд ХАЗ-ийн ажилд оролцсон байдлыг харгалзан ажлын хөлс олгох бөгөөд түүний хэмжээг ХАЗ-ийн даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална.

6.2.ХАЗ-ийн үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсвийг жилийн эхэнд ХАЗ-ийн даргын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч батална.

#### **Долоо. ХАЗ-д төлөөлөх эрх бүхий албан тушаалтныг томилох, нөхөн томилох**

7.1.ХАЗ-д байгууллагаа төлөөлөн оролцох эрх бүхий албан тушаалтныг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 22 дугаар зүйлийн дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч томилно.

7.2.ХАЗ-ийн дарга, эрх бүхий албан тушаалтан нь хугацаанаасаа өмнө үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн тохиолдолд түүнийг орлох албан тушаалтныг нөхөн томилно.

\_\_\_\_\_oOo\_\_\_\_\_

Монголбанкны Ерөнхийлөгчийн  
2014 оны 7 дугаар сарын 11-ны өдрийн  
A-116 дугаар тушаалын хөөрдугаар хавсралт



**ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ**

УХИНЮУ14

\_\_\_\_ оны \_\_\_\_-р сарын \_\_\_\_-ны өдөр Дугаар Улаанбаатар хот

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан Хамтын ажиллагааны зөвлөл \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн Хамтын ажиллагааны зөвлөлийн хуралдааны/уулзалтын шийдвэрт үндэслэн \_\_\_\_\_ хууль/журам/уулзалтын протоколыг удирдлага болгон дараах зөвлөмжийг \_\_\_\_\_-д хүргүүлж байна. Үүнд:

1. \_\_\_\_\_ зөвлөсүгтэй (санал болгосугай)
2. \_\_\_\_\_
3. \_\_\_\_\_
4. \_\_\_\_\_
5. Энэ зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүддэд танилцуулахыг \_\_\_\_\_-д зөвлөсүгтэй.

ДАРГА

ГАРЫН ҮСЭГ